

**ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ
(2022 оны II-р улирлын дүнгийн тухай)**

2022 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 2022 оны II-р улирлын байдлаар зохион байгуулан ажиллалаа.

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас нийт 124 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем /<https://erp.ulaanbaatar.mn> /-д бүртгэн, 113 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан бол 9 өргөдөл шийдвэрлэх шатандаа явагдаж байна. Өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног, 23 цаг, 0 минут.

Эхний хагас жилийн хугацаанд байгууллагад хандан иргэнээс 1800-1200 утсаар дамжин ирсэн 1 өргөдлийг дэд системд системийн горимын дагуу бүртгэсэн болно. Хүсэлтийн хариуг шуурхай шийдвэрлэн иргэнд утсаар мэдэгдсэн.

Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ /өссөн дүнгээр/

2022 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагад ирсэн өргөдлийг хандалтыг төрлөөр нь ангилбал:

- Иргэнээс гаргасан санал, хүсэлт-1
- Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл-3
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл– 11
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл– 12
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл– 16
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл- 39
- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл- 42

Өргөдөл гомдлын төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь үзүүлбэл:



График 1. Өргөдлийг төрлөөр нь ангилсан байдал.

Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үеүүдтэй харьцуулсан байдал

Хүснэгт1

Д/д	Хугацаа	2021.02 улирал	2021.03 улирал	2021.04 улирал	2022.01 улирал	2022.02 улирал
Ерөнхий үзүүлэлт						
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	6 хоног 7 цаг 26 минут	4 хоног 15 цаг 59 минут	4 хоног 21 цаг 59 минут	7 хоног, 0 цаг, 54 минут	10 хоног 23 цаг 1 минут
2	Хандалтын тоо	26	36	54	42	124
3	Зөрчлийн үзүүлэлт	0	0	0	11	2
Өргөдөл гомдлын хандалтын төрөл						
4	Иргэнээс гаргасан санал, хүсэлт	0	0	1	0	1
5	Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл	1	0	0	0	3
6	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл	10	10	13	3	8
7	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл	5	5	8	9	3
8	Захиргааны чөлөө хүссэн өргөдөл	2	8	1	7	9
9	Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл	9	10	15	15	14
10	Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл	0	3	14	8	34




График 2. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг өмнөх улиралтай харьцуулсан байдал

Графикаас харахад газрын хэмжээнд 2022 оны эхний хагас жилд ирсэн өргөдлийн тоо өмнөх улирлаас 33.8 хувиар, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоногоор тус тус өссөн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 23 цаг 1 минут байгаа нь 2021 оны дундаж хугацаанаас буурсан нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т хугацааг баримтлан шийдвэрлэж буйтай холбоотой юм. Мөн байгууллагын дотоод журамд заасан ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хүссэн өргөдлийг ажлын байрны ачаалалд мониторинг хийсний дараа уг хүсэлтийг шийдвэрлэж буйтай холбоотой юм.

Ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан технологийн шийдэл ашиглан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд манай байгууллагад хамааралгүй 2 өргөдөл гомдлыг холбогдох байгууллагад өдөрт нь шилжүүлэн ажиллалаа.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Б.ХЭНМЭДЭХ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН
АЖИЛТАН

А.НОМИНЗУЛ